

ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГӨӨР 2018 ОНЫ ТӨСВИЙН ЖИЛД ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БУЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

Нэг. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа болон шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний танилцуулга.

Монгол Улсын 2018 төсвийн төсөлд гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний хүрээнд гарах ашиглалтыг тооцоолохдоо хэрэгжилтийн явц байдал, дуусах хугацаатай уялдуулж тооцсон бөгөөд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 6.3.4 дэх заалт, Өрийн удирдлагын тухай хуулийн 18.5 дахь хэсэг болон холбогдох бусад хууль, тогтоомжид нийцүүлэн, тусгах зарчим баримталаа.

Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр 2018 оны төсвийн жилд нийт 126 төсөл, арга хэмжээнд 1.1 их наяд төгрөгийн эдийн засаг, нийгмийн үр ашигтай төслүүд болох эрчим хүч, боловсруулах үйлдвэр, дэд бүтцийн салбарын төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд ашиглахаар төлөвлөж байна. Тухайлбал, БНХАУ-ын 1.0 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр “Улаанбаатар-Мандалговь цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төсөл”, “Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто зам барих төсөл”, Япон Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг барих төслийг бүрэн дуусгаж, ашиглалтад оруулах, БНЭУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр “Газрын тос боловсруулах үйлдвэрийг барих төсөл” зэрэг томоохон төсөл, арга хэмжээнүүдийг санхүүжүүлэн, хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

2018 оны төсвийн жилд хэрэгжих төсөл арга хэмжээг эдийн засаг, нийгмийн ач холбогдлоор нь авч үзвэл. Үүнд:

1. Улаанбаатар хотын авто замын түгжрэл, нийслэл хотын дэд бүтцийг хөгжүүлэх, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр дараах томоохон төсөл, хөтөлбөрүүдийг шинээр болон үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Тухайлбал, Азийн хөгжлийн банк болон Европын хөрөнгө оруулалтын банкны хөнгөлөлттэй зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр, төслийн эхний шатны санхүүжилтээр нийслэл хотын Баянхошуу болон Сэлбэ дэд төвүүдийг байгуулах, энэ бүсэд амьдарч буй айл өрхийг инженерийн шугам, сүлжээнд холбох, дэд бүтцийн хангамж үйлчилгээг өргөтгөх, суурь үйлчилгээний хүртээмж болон чанарыг сайжруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл, тусламжийн хөрөнгөөр Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотын хэмжээнд нийт тээврийн хэрэгслээр зорчиж буй зорчигчдын 55 хувийг хамардаг Энхтайваны өргөн чөлөөний дагуу Тусгай замын зорчих тээврийн хэрэгслийг шинээр нэвтрүүлэх замаар авто замын түгжрэлийг 2025 онд 20 хувь хүртэл, 2030 онд 30 хувь хүртэл бууруулах, мөн БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Нүхэн гарц төслийн хүрээнд Нарны зам дагуу 7 байршилд төмөр замын доогуур нүхэн гарцыг байгуулж, хотын уулзваруудын нэвтрэх хурдыг нэмэгдүүлж, авто замын ачааллыг бууруулах бол, Туул гол дээгүүр Баянзүрхийн 288 метр, Сонсголонгийн 289.4 метр төмөр бетон гүүр барих төсөл, Яармагийн шинэ гүүр барих, хуучин гүүрийг сэргээн засварлах төслүүдийн хүрээнд авто замын дэд бүтцийг сайжруулж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ач холбогдолтой байна. Мөн, Улаанбаатар хотоос–Хөшигтийн хөндийн олон улсын шинэ нисэх онгоцны буудал хүртэлх нийт 32.2 км хатуу хучилттай, 32.5 метр зорчих хэсгийн өргөнтэй, 2 урсгал, 6 эгнээтэй хурдны авто замыг тавьснаар тээврийн хэрэгслийн түргэн зорчих боломжийг нэмэгдүүлэх юм. Түүнчлэн, зам, тээврийн осол их гарч байгаа ашиглалтын хугацаа нь дууссан

Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замыг өргөтгөн, шинэчилснээр зам, тээврийн ослыг бууруулахаас гадна нийслэл хотын авто замын дэд бүтцийг сайжруулна.

2. Экспортыг нэмэгдүүлэх, хилийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр дараах төсөл, хөтөлбөрүүдийг шинээр болон үргэлжлүүлэн, хэрэгжүүлнэ.

Гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, экспортыг дэмжих, хилийн боомтуудын нэвтрэх хүчин чадлыг сайжруулах зорилгоор Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр “Хилийн үйлчилгээг сайжруулах төсөл”, “Ургамал малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах төсөл”-ийн хүрээнд гааль, хилийн албаны тоног төхөөрөмжийг шинэчлэх, БНХАУ-ын тусламжийн хөрөнгөөр хилийн боомтуудын албан хаагчдын амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууц барих, дэд бүтцийг сайжруулах зэрэг төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ. Түүнчлэн, экспортыг дэмжих чиглэлээр Дэлхийн банкны санхүүжилтээр “Экспортыг дэмжих төсөл”, Японы ОУХАБанкны зээлийн хөрөнгөөр “Экспортын зээлийн шугам нээх төсөл”-ийг хэрэгжүүлэхээс гадна жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилтын хүрээнд Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төсөл”, ХААХОУС-ийн зээлийн хөрөнгөөр “Зах зээл ба бэлчээрийн удирдлага төсөл” зэрэг төслүүдийг тус тус хэрэгжүүлнэ.

3. Боловсролын салбарын хүртээмж, 3 ээлжээр хичээллэж буй ЕБС-иудын тоог бууруулах, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр дараах томоохон төсөл, хөтөлбөрүүдийг шинээр болон үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан бодлого, зорилтуудад тусгагдсан боловсролын салбарын хүртээмж, чанарыг сайжруулж, эрчимжүүлэхэд улсын төсвийн хөрөнгө оруулалтаас гадна гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрийг түлхүү авч ашиглана. Үүнд: Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар ба хүртээмжийг дэмжих төсөл”-ийн хүрээнд нийт 3 сургууль, 7 цэцэрлэгийг Баянзүрх, Сонгинохайрхан, Налайх дүүргүүд болон Дархан-Уул аймагт шинээр барих ба 8 сургууль, 17 цэцэрлэгийн өргөтгөлийн ажлыг Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар, Налайх дүүргүүд болон Алтай, Говьсүмбэр, Сайншанд суманд хийх бол, Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Нийслэлийн Хан-Уул, Чингэлтэй дүүргүүдэд 2 сургуулийн барилга шинээр барьж, Баянзүрх, Налайх дүүрэгт 2 сургуулийн өргөтгөл хийх, БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 7 сургуулийн барилгыг нийслэлд, Архангай аймагт 1 цэцэрлэгийг шинээр барих ажлыг тус тус гүйцэтгэнэ. Түүнчлэн, БНСУ-ын Засгийн газраас авах 500.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл, БНХАУ-ын 1.0 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хуваарилагдаагүй хөрөнгөөс сургууль, цэцэрлэг, дотуур байрыг нэмэгдүүлэх багц төсөл, арга хэмжээг зээлдүүлэгч талтай хэлэлцэн тохиролцож, хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

4. Эрүүл мэндийн салбарын хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх чиглэлээр дараах төсөл, хөтөлбөрүүдийг шинээр болон үргэлжлүүлэн, хэрэгжүүлнэ.

Эрүүл мэндийн салбарын хөгжлийг эрчимжүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах зорилгоор Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4 төсөл”-ийн хүрээнд нийслэлийн хүн амын суурьшил ихтэй Сонгинохайрхан дүүрэгт шинээр олон улсын стандартад нийцсэн жишиг нэгдсэн эмнэлэг барих, БНСУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр “Үндэсний оношилогоо, эмчилгээний төв байгуулах төсөл”, Кувейтийн Засгийн газрын буцалтгүй тусламжаар “Түлэнхийн төв барих төсөл”, Австрийн Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр “Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн тоног төхөөрөмжийг шинэчлэх - 2 шаг” төслүүдийг хэрэгжүүлнэ. Түүнчлэн, эрүүл мэндийн салбарт БНХАУ болон БНСУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөс багц төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөлөө.

5. Орон нутгийн хөгжлийг хангах, дэд бүтцийг сайжруулах чиглэлээр дараах төсөл, хөтөлбөрүүдийг шинээр болон үргэлжлүүлэн, хэрэгжүүлнэ.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Дархан-Уул, Архангай, Өвөрхангай, Дорноговь, Өмнөговь, Хөвсгөл, Хэнтий, Увс, Булган болон Дундговь аймгуудад бохир усны цэвэрлэх байгууламжийг сайжруулах, шинээр барьж байгуулах, Францын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөх төслийг дуусгаж, ашиглалтад оруулах, БНПУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Баян-Өлгий аймаг, Говьсүмбэр аймгийн Чойр сум, Дорнод аймгийн Чойбалсан сумдын цэвэрлэх байгууламжийг шинээр барих, Австрийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжих “Тайшир-Алтай ус хангамж төсөл”-ийн хүрээнд Говь-Алтай аймгийн Алтай хотын усан хангамжийн асуудлыг шийдвэрлэх, мөн тус улсын санхүүжилтээр Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэг, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн төвүүдийн гэр хорооллын гудамж, талбайн гэрэлтүүлэг, камержуулалтын ажлыг хийж, иргэдийн аюулгүй тайван амьдрах нөхцөл, бололцоог бүрдүүлэх бол БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр нийт аймгуудын төвүүд, нийслэл хотын гудамж, талбайг камержуулна. Мөн, БНСУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “10 аймгийн төвийн дулааны станц барих төсөл”-ийн хүрээнд Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Төв, Сүхбаатар аймгуудын төвийн дулааны станцтай төвлөрсөн дулаан хангамжийн системд шилжүүлэн техник, технологийн шинэчлэлт хийх, оршин суугчдыг найдвартай халаалт, хэрэглээний халуун усаар тогтмол хангах, ая тухтай орчинг бүрдүүлэх, орон нутгийн хөгжлийг эрчимжүүлэх төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөлөө.

Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр 2018 оны төсвийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл арга хэмжээг төсвийн ерөнхийлөн захирагчаар авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ

/сая төгрөг/

Төсвийн ерөнхийлөн захирагч	Гадаад зээл Тоо	Дүн /сая төгрөг/	Гадаад тусламж Тоо	Дүн /сая төгрөг/	Total Тоо	Total Дүн /сая төгрөг/
01. Монгол Улсын Их Хурлын дарга			1	2,684.9	1	2,684.9
02. Монгол Улсын Ерөнхий сайд	1	10,761.4			1	10,761.4
03. Монгол Улсын Шадар сайд	2	7,433.7	1	2,006.0	3	9,439.7
04. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	1	7,762.5	1	265.2	2	8,027.7
05. Барилга, хот байгуулалтын сайд	7	41,420.4	1	343.2	8	41,763.6
06. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	1	87.6	7	9,979.4	8	10,067.0
07. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	8	79,317.3	4	56,969.1	12	136,286.4
08. Сангийн сайд	16	134,995.8	3	17,171.2	19	152,167.1
09. Зам, тээврийн хөгжлийн сайд	12	293,582.6	1	920.4	13	294,503.0
11. Хууль зүй, дотоод хэргийн сайд	3	10,772.1	1	625.5	4	11,397.6
12. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	4	9,578.2	2	1,414.6	6	10,992.8
13. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	4	16,134.1	2	9,513.7	6	25,647.8
15. Эрүүл мэндийн сайд	8	70,565.1	3	2,015.0	11	72,580.1
16. Эрчим хүчний сайд	9	99,870.4	3	4,016.0	12	103,886.4
17. Монгол Улсын ерөнхий прокурор			1	300.2	1	300.2
18. Монгол Улсын ерөнхий аудитор			1	87.6	1	87.6
19. Үндэсний статистикийн газрын дарга			1	24.4	1	24.4
25. Нийслэлийн Засаг дарга	13	49,418.7	3	1,663.6	16	51,082.3

26. Дархан-Уул аймгийн Засаг дарга	2	4,200.0		2	4,200.0
НИЙТ ДҮН	91	835,900.0	36	110,000.0	127

Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээг Төсвийн ерөнхийлөн захирагч, санхүүжүүлэгч тус бүрээр дэлгэрэнгүй авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

2.1. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

2.1.1. Монгол Улс дахь төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр, Швейцарын хөгжлийн агентлаг
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	3.8 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	2,684.9 сая төгрөг

Иргэдийн төлөөллийн байгууллага, нутгийн удирдлагын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохион байгуулах, чадавхыг бэхжүүлэхэд оршино.

2.2. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

2.2.1. Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	21.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	15,761.4 сая төгрөг

Үндэсний радио долгионы хяналт харилцаа холбооны тоног төхөөрөмжийн баталгаажуулалт, Монгол Улсын төрийн өмчийн шилэн кабелийн үндсэн сүлжээний хүртээмж, чанарыг сайжруулахад орших бөгөөд төслийн хүрээнд тоног, төхөөрөмжүүд, радио долгион хяналтын станцууд нийлүүлэгдэнэ.

2.3. МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД

2.3.1. Зудын болон ой сав, тал газарт гарах гамшгийг даван туулах чадавхыг бэхжүүлэх төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	3.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	2,006.0 сая төгрөг

Иргэдийн бүлгүүдийг байгуулж, орон нутагт суурилсан гамшгийн эрсдэлийн удирдлага (ОНСГЭУ)-ын арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлэх механизмуудыг туршин нэвтрүүлэх замаар орон нутгийн гамшгийн эрсдэлээс сэргийлэх, сэргээн босгох чадавхыг бэхжүүлэхэд чиглэгдэнэ. Төслийн үйл ажиллагаа нь ядуурлыг бууруулахад чиглэсэн, оролцооны зарчимд тулгуурлана.

Төсөл нь сумын төвд оршин суудаг 2,500, тэр дундаа 250 өрх толгойлсон эмэгтэй өрхийн нийт 7,000 малчин байх бол шууд бус байдлаар олон нийтийг илүү өргөн хүрээгээр хамруулж, төсөл хэрэгжих зорилтот сумдын нийт 32,000 хүн амд хүрнэ. Энэхүү төсөл нь Монгол улсад гамшгийн эрсдэлийн удирдлага (ГЭУ)-д олон нийтийн оролцооны босоо чигийн зохион байгуулалттай механизмыг туршин нэвтрүүлэх анхны тохиолдол болно.

2.3.2. Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг шинэчлэн сайжруулах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	10.7 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	2,800.0 сая төгрөг

Мал, ургамлын эрүүл ахуйн хяналт шалгалтын тогтолцоог Дэлхийн Худалдааны Байгууллагын тавьдаг шаардлагын төвшинд хүргэх, мал, ургамлын гаралтай хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүний импорт болон экспортыг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд төслийн зорилго оршино.

2.3.3. Гал түймэртэй тэмцэх техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНПУ-ын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	3.0 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	4,633.7 сая төгрөг

Төслийн зорилго нь Онцгой байдлын байгууллагад ашиглагдаж байгаа гал түймэр унтраах аврах, эрэн хайх зориулалтын автомашин техникийг олон улсын төвшинд хүргэх, гал түймэр унтраах аврах ангиудын техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, олон улсын жишигт нийцсэн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж, аврах, эрэх хайх, гал түймэртэй тэмцэх чадавхыг сайжруулах, бэлтгэл бэлэн байдлыг хангуулахад төслийн зорилго оршино.

2.4. ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

2.4.1. Олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Дэлхийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	450.0 мянган ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	265.2 сая төгрөг

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг (ОУИТБС) хэрэгжүүлэх ажлыг боловсронгуй болгох, үр дүнг дээшлүүлэх ажлын хүрээнд Засгийн газар, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын үүрэг оролцоог тодорхойлж, олон нийтэд байгалийн нөөц баялгийн ашиглалтыг нээлттэй ил тод байдлыг бий болгоход чиглэгдэнэ.

2.4.2. Ухаалаг засаг төсөл /ДБ/

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Дэлхийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	12.6 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2015-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	7,762.5 сая төгрөг

Цахим Засаг үндэсний хөтөлбөрийн хүрээнд Цахим Засгийг хөгжүүлэх эрх зүйн орчныг сайжруулах, мэдээлэл технологийн дэд бүтцийг хөгжүүлэх, Засгийн газрын мэдээллийг цахимжуулах, иргэдэд төрийн үйлчилгээг онлайн хэлбэрээр хүргэх, иргэдийн технологийн хэрэглээний тэгш бус байдлыг багасгах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зорилготой.

2.5. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД

2.5.1. Зүүн өмнөд Говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл

Санхүүжилтийн нийт хэмжээ	20.0 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	7,000.0 сая төгрөг

Төслийн зорилго нь төсөлд хамрагдсан хотуудын эдийн засгийн хөгжлийг дэмжих, үр ашигтай, зөв төлөвлөх, чанартай, найдвартай, өргөн хүрээг хамарсан нийтийн аж ахуйн үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлэх болон нийтийн ахуйн үйлчилгээний тогтвортой байгууллагыг бий болгоход чиглэж байна.

2.5.2. Зүүн өмнөд говийн хот, хил орчмын хотын хөгжил төслийн нэмэлт санхүүжилт /Өмнөговь, Дорноговь/ MON-3388

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	21.9 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2010-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	343.2 сая төгрөг

Төслийн зорилго нь экологийн даацыг бууруулахгүй хотын иргэдийн тав тухтай амьдрах орчныг хангасан уул уурхай, барилга, барилгын материал, хүнсний үйлдвэрлэл, газрын тос боловсруулах үйлдвэр, эрчимжсэн ХАА, тээвэр ложистик, шинжлэх ухаан, боловсролын цогцолборт тулгуурласан төв болгон хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, цэвэрлэгдсэн бохирыг цаашид ногоон байгууламжийн усжуулалт, үйлдвэр болон технологийн хэрэглээнд ашиглах боломжийг бүрдүүлэх, мөн хэрэглээнээс гарсан бохир усыг үндэсний стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэх бүтээмж өндөртэй, эрчим хүчний хэмнэлттэй шинэ технологийн тоног төхөөрөмж бүхий бүрэн биологи цэвэрлэгээний байгууламжийг ашиглалтад оруулахад оршино

2.5.3. Орон сууцны хороолол, дэд бүтэц төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	99.9 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2011-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	6,024.1 сая төгрөг

Улаанбаатар хотын VII дугаар хороолол, XIV дүгээр хороололд баригдах орон сууцны барилга, VII дугаар хороолол, МҮОНРТ-ийн орчимд баригдах орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг гүйцэтгэнэ. Улаанбаатар хотын VII-р хороолол, Монголын Радио телевизийн хэрэг эрхлэх газрын орчмын орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээ, VII, XIV-р хороололд баригдах 2592 айлын орон сууцны барилга угсралт, инженерийн шугам сүлжээний угсралтын ажил хийгдэнэ.

2.5.4. Дэд бүтцийн хөгжил-Баянзүрх, Дархан, Сэлэнгэ төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Австри Улсын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	5.0 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	2,021.1 сая төгрөг

Аймаг, нийслэлийн иргэдийн аюулгүй, тав тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хүн амын тоо өндөр, гэр хорооллын дэд бүтэц бага хөгжсөн Баянзүрх дүүрэг болон Дархан хотын алслагдсан хороод, Сэлэнгэ аймгийн дэд бүтцийг хөгжүүлэх, алслагдсан баг, хороодын гудамж талбайг камержуулах, гэрэлтүүлгийн ажлууд хийгдэнэ.

2.5.5. Дэд бүтцийн хөгжил-Сонгинохайрхан төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Австри Улсын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	7.0 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	7,169.6 сая төгрөг

Нийслэлийн иргэдийн аюулгүй, тав тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хүн амын тоо өндөр, гэр хорооллын дэд бүтэц бага хөгжсөн Сонгинохайрхан дүүргийн дэд бүтцийг хөгжүүлэх, алслагдсан хороодын гудамж талбайг камержуулах, гэрэлтүүлгийн ажлууд хийгдэнэ.

2.5.6. Тайшир-Алтай ус хангамж төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Австри Улсын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	14.0 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	10,339.2 сая төгрөг

Говь-Алтай аймгийн төв Алтай хотод 6000 орчим өрхөд 20000 гаруй хүн ам ажиллаж амьдарч байгаа бөгөөд Алтай хотын усан хангамжийн усны нөөцийн одоо ашиглаж байгаа эх үүсвэр нь хүн амын ундны усны стандартыг хангадаггүй, кальци, магнийн харьцаа алдагдсан, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаагаас гадна усны нөөцийн хэмжээ ус хэрэглээний өнөөдрийн хэрэгцээг хангаж чадахгүй болоод байна. Энэхүү төсөл Говь-Алтай аймгийн Алтай хотын 20 гаруй мянган хүн амын ундны усны хэрэгцээг хангах чухал холбогдолтой юм.

2.5.7. Зүүн өмнөд Говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт - 2

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	20.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	175.1 сая төгрөг

Төслийн зорилго нь төсөлд хамрагдсан хотуудын эдийн засгийн хөгжлийг дэмжих, үр ашигтай, зөв төлөвлөх, чанартай, найдвартай, өргөн хүрээг хамарсан нийтийн аж ахуйн үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлэх болон нийтийн ахуйн үйлчилгээний тогтвортой байгууллагыг бий болгоход чиглэж байна.

2.5.8. Аймгийн төвүүдийн бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх, шинээр барих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНПУ-ын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	9.9 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	8,691.3 сая төгрөг

Баян-Өлгий аймаг, Завхан аймгийн Улиастай сум, Сүхбаатар аймгийн Баруун урт, Говь Сүмбэр аймгийн Чойр сум, Дорнод аймгийн Чойбалсан сум, Сэлэнгэ аймгийн Хөтөл сум, Дархан –Уул аймгийн Шарын гол сумдын 1970-1990 онуудад баригдсан элэгдэж хуучирсан бохир ус цэвэрлэх байгууламжуудыг шинэчлэх, шинээр барьснаар иргэдийн эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилготой.

2.6. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД

2.6.1. Байгалийн нөөцийн менежмент бүхий хамгаалалттай газар нутгийн сүлжээ төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Нэгдсэн Үндэсний Байгууллага
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	1.5 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2013-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	112.4 сая төгрөг

Монгол орны олон янз экосистемийн нэгдмэл байдлыг хангаснаар дэлхийн хэмжээнд ач холбогдол бүхий биологийн төрөл зүйлийн оршин байх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино

2.6.2. Монгол орны UN-REDD Үндэсний Хөтөлбөр

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Нэгдсэн Үндэсний Байгууллага
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	3.9 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2015-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	1,480.5 сая төгрөг

Монгол орны UN-REDD Үндэсний Хөтөлбөрийн ерөнхий зорилго нь Монгол Улсын Засгийн Газарт Үндэсний REDD-ийн стратегийг боловсруулж, хэрэгжүүлэх, мөн Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын Варшавын тунхаглалын шаардлагуудтай нийцүүлэн REDD-ийн үр дүнд суурилсан урамшууллыг хүртэхэд туслалцаа үзүүлэх юм.

2.6.3. Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг боловсронгуй болгох замаар хөрсний бохирдлыг бууруулах төсөл – MON49113

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	3.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	555.5 сая төгрөг

Төслийн хэрэгжсэнээр гэр хорооллын бүсэд нийгмийн эрүүл мэндийн нөхцөл сайжирч, хөрсний бохирдол буурна. Төслөөс хүлээж буй үр дагаврын хувьд сайжруулсан ариун цэврийн байгууламжийг гэр хороололд нэвтрүүлэх болон хүний хаягдал ялгадсаас үүдэлтэй хөрсний бохирдлыг бууруулах загвар үйл ажиллагаануудыг туршин хэрэгжүүлнэ.

2.6.4. Хөвсгөл нуурын байгалийн цогцолборын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл 9183-MON

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	3.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	1,033.0 сая төгрөг

Хөвсгөл нуур орчмын өрхийн амьжиргааг дээшлүүлэх, байгалийн баялгийн удирдлагыг сайжруулах, аялал жуулчлалыг дэмжих юм. Үүнд:

- Хатгал, Ханх сууринд нутгийн хүн амд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх,
- Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын орчны бүс /Хатгал тосгон, Алаг-Эрдэнэ, Ханх, Ринченлхүмбэ, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сум/-ийн иргэдийн амьжиргааг сайжруулах,
- Мал аж ахуйн үйлдвэрлэл, бэлчээрийн менежмент сайжирч малчдын орлогыг төрөлжүүлэх, нэмэгдүүлэх,
- Хөвсгөл нуур орчмын хог хаягдлын менежментийн загварыг бий болгоно.

2.6.5. Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	ХБНГУ-ын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	15.3 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2013-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	6,051.0 сая төгрөг

Монгол Улсын тусгай хамгаалалттай газрын менежментийн систем (дэмжих бүс болон экологийн коридор)-ийг чадавхижуулах, тэр дундаа уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой зөвлөмж гаргах, хөрөнгө оруулалт хийх, орон нутгийн хүн амын амьжиргааг дээшлүүлэх, тогтворжуулна. Уг төсөл нь уур амьсгалын нөлөөллийг харгалзаж үзэн, биологийн төрөл зүйлийг хамгаалах, амьжиргааны төвшнийг сайжруулах

чиглэлээр хэрэгжүүлж байгаа Монгол-Германы хамтарсан “Биологийн төрөл зүйл” хөтөлбөрийн зорилгыг биелүүлэх үндсэн үйл ажиллагаа юм.

2.6.6. Монгол орны баруун бүсэд газрын доройтол, хөгжлийн сөрөг нөлөөллийг бууруулах, дүйцүүлэн хамгааллыг нэвтрүүлэх төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Нэгдсэн Үндэсний Байгууллага
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	1.3 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	371.7 сая төгрөг

Монгол орны баруун бүсэд хөгжлийн сөрөг нөлөөлөл, газрын доройтлыг бууруулах үе шат, дүйцүүлэн хамгааллыг ландшафтын төвшний төлөвлөлт, менежментэд нэвтрүүлэх замаар уул уурхайгаас бэлчээрт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад төслийн зорилго оршино. Цаашид төслийн зорилгот сумдын доройтсон бэлчээрт худаг гаргах, булаг шанд тохижуулах, хөв цөөрөм байгуулах аргаар бэлчээрийн ургач чадварыг нэмэгдүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлнэ.

2.6.7. Тогтвортой аялал жуулчлалыг дэмжих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	38.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2023
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	87.6 сая төгрөг

Аялал жуулчлалыг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх, дэд бүтцийг шийдвэрлэх, цаашилбал нийгмийн амьжиргааг дээшлүүлэхэд оршино.

2.6.8. Мазаалай баавгайн амьдрах орчны нөхцөлийг сайжруулах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	1.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	375.3 сая төгрөг

Мазаалай баавгайг байгалийн нөхцөлд нь хамгаалахын тулд түүний амьдрах орчны таатай нөхцөлийг дэмжин тэтгэх замаар амьдрах боломжтой орон зайг нь аль болох тэлэх, амьдрах орчны чанарыг илэрхийлэх түлхүүр хүчин зүйлийн /уст цэг, идэш тэжээлийн нөөц, нуугдах хоргодох боломжтой газар нутаг/ нөлөөллийг нэмэгдүүлэхэд оршино.

2.7. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД

2.7.1. Баруун бүсийн бага ангийн сурагчдын дотуур байрны нөхцөлийг сайжруулах төсөл – JFPR9182

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	3.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2015-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	1,316.7 сая төгрөг

Төслийн зорилго нь хүүхэд бүрд, ялангуяа малчин өрхийн хүүхдэд чанартай боловсролыг тэгш, хүртээмжтэй эзэмшүүлэх үүднээс баруун бүсийн 3 аймагт сургуулийн дотуур байрны материаллаг орчин, үйлчилгээг сайжруулах загвар тогтоон, хэрэгжүүлэхэд оршино. Төсөл нь Говь-Алтай, Завхан, Увс аймгийн 20 сургуульд хэрэгжих бөгөөд 2017-18 оны хичээлийн жилд суралцаж буй нийт 5526 бага ангийн сурагчид, эдгээр сургуулийн дотуур байранд амьдарч буй малчдын хүүхдүүдэд төслийн үр дүн шууд хүрнэ.

2.7.2. Дээд боловсролын шинэчлэл төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
--	---------------------

Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	12.6 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2012-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	3,820.5 сая төгрөг

Дээд боловсролын хөтөлбөрийн чанар, нийлэмж, дээд боловсролын засаглал, удирдлага, санхүүжилтийн үр өгөөж болон тэгш байдал, хүртээмжийг сайжруулах замаар Монгол улсын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцэхүйц, дэлхийн хэмжээнд өрсөлдөх чадвартай их, дээд сургууль төгсөгчдийн тоог нэмэгдүүлэхэд оршино.

2.7.3. Боловсролын чанарын шинэчлэл төсөл /ДБ/

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Дэлхийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	19.5 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	10,392.4 сая төгрөг

Бага боловсролын эх хэл, байгалийн ухаан ба математикийн сургалтын чанар, үр дүнг сайжруулж, сургуулийн төвшинд төлөвлөлтийг бэхжүүлэх замаар бага боловсролын чанарыг сайжруулахад оршино.

2.7.4. Ухаалаг боловсрол

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНСУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	19.6 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	9,824.4 сая төгрөг

Төслийн зорилго нь уламжлалт сурах бичигтэй хослуулан төрөл бүрийн мультимедиа, интерактив контент ашиглах, анги танхимд багш төвтэй сургалт явагдах, мэдээллийн технологид суурилсан сургалтад үе шаттай шилжих боломж бүрдэхэд оршино. Төсөлд Монгол Улсын 150 төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудыг хамруулж, шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлэх, суурилуулах, төсөлд хамрагдаж буй багш нарын мэргэжлийг дээшлүүлэх, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэгдэхэд ашиглагдах дижитал тоног төхөөрөмжийг эх хэл дээр ашиглах нөхцөл бололцоогоор хангана.

2.7.5. Шинэ зууны боловсрол төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	45.7 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	5,374.6 сая төгрөг

Төслийн хүрээнд нийслэлийн 97, аймгийн төвийн 55, сумын 473, нийт 625 сургууль шилэн кабел бүхий интернетийн үйлчилгээг хүртэх боломжтой болно. Түүнчлэн, боловсролын салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгох нөхцөл бүрдэх бөгөөд төслийн хүрээнд нийт 25 мянган компьютер нийлүүлж сургуулийн багш нарыг 100% зөөврийн компьютерээр хангаж, сурагч, багш нарын хооронд мэдээллийг түргэн шуурхай авах, E-контентийг хэрэглэх орчин бүрдэнэ.

2.7.6. Мэдээллийн технологийн боловсрол болон аутсорсингийн төвийг байгуулах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНЭУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	20.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2015-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	8,921.8 сая төгрөг

Олон улсын төвшинд хүрэхүйц мэргэжлийн өндөр ур чадвартай хүний нөөцийг нэмэгдүүлэх, мэдээллийн технологийн гадаад аутсорсингийг хөгжүүлэх зорилгоор олон улсын жишигт нийцсэн

мэдээллийн технологийн боловсрол, аутсорсингийн төвийг байгуулж, улмаар мэдээллийн технологийн салбараар дамжуулан Монгол Улсын экспортыг дэмжихэд төслийн зорилго оршино.

2.7.7. Инженер технологийн дээд боловсрол төсөл MON-P11 /Япон/

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Япон Улсын Засгийн газар – ЯОУХААБ
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	6.8 тэрбум иен
Төсөл хэрэгжих хугацаа	2014-2023
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	25,660.1 сая төгрөг

Монгол Улсад өндөр мэдлэг, ур чадвар бүхий инженер, технологийн мэргэжилтэн бэлтгэх, инженерийн боловсролын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, багшлах боловсон хүчний нөөцийг бэхжүүлэх, сургалтын орчныг шинэчлэх, чанарыг сайжруулахад оршино.

2.7.8. Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар ба хүртээмжийг дэмжих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	50.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	8,756.3 сая төгрөг

Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөртэй уялдуулж 3 ээлжээр ажиллаж байгаа сургуулиудыг 2 ээлжид шилжүүлэх, сургуулиас өмнөх, бага болон дунд сургуулиудын боловсролын чанарыг сайжруулах юм.

2.7.9. Ерөнхий боловсролын сургууль барих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	300.0 сая юань
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	20,233.7 сая төгрөг

Төслийн хүрээнд Сонгинохайрхан дүүргийн 6-р хороо, 25-р хороо, 26-р хороо, Баянзүрх дүүргийн 12-р хороо, 19-р хороо, Хан-Уул дүүргийн 15-р хорооны сургууль болон Архангай аймгийн цэцэрлэгийн барилгыг тус тус барина.

2.7.10. Өрсөлдөх чадвартай дээд боловсрол төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	23.7 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	6,567.3 сая төгрөг

МУИС-ийн шинэ номын сангийн барилгыг тавилгажуулж, орчин үеийн ухаалаг системээр бүрэн тоноглогдсон, сургалт-судалгаа-мэдээллийн цоо шинэ цогц орчинг бүрдүүлэх, одоо байгаа МУИС-ийн барилгад лабораторийн нарийн шаардлага, үзүүлэлтийг хангасан барилгын өргөтгөл барьж, тоноглоход төслийн санхүүжилт зарцуулагдана. Төсөл хэрэгжсэнээр дараах үр дүнд хүрнэ.

- "Боловсролын талаар төрөөс баримтлах бодлого"-оор төрөөс өгсөн даалгаврыг биелүүлэх нөхцөл бүрдэж, "МУИС-ийг 2016-2024 онд хөгжүүлэх стратегийн төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх суурь нь тавигдана.
- Улс орны хэмжээнд нээлттэй үйл ажиллагаа явуулах, дэвшилтэт технологи бүхий тоног төхөөрөмжтэй лабораторитой болно.
- Монгол улсын сургалт, эрдэм шинжилгээ эрхэлдэг бусад их сургууль, судалгааны байгууллагын эрдэмтэдтэй хамтын судалгаа хийх нөхцөл бүрдэнэ.

- Судалгааны чанарыг илүү өндөр төвшинд гаргаж, МУИС-ийн эрдэмтдийн олон улсын нэр хүнд бүхий сэтгүүлд хэвлүүлэх бүтээлийн тоо өснө.
- Оюутны суралцах орчин эрс сайжирч, “ухаалаг” боловсролын тогтолцоо бүрдэж, сургалтын чанар дээшилж, оюутны сэтгэл ханамж өснө.
- Азид өрсөлдөх чадвартай их сургуулийг цогцлуулах суурь нөхцөлийг бүрдүүлэхэд энэ төслийн ач холбогдол оршино.

2.7.11. Ерөнхий боловсролын сургуулийн барилга барих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Япон Улсын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	10.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	125.1 сая төгрөг

Улаанбаатар хотод өндөр чанартай бага дунд боловсролын сургалтын байрыг барьж, барилга байгууламжийн тоо хүрэлцээгүй байдлыг сайжруулах, боловсролын салбарыг хөгжүүлэх зорилготой. Үүний дагуу Улаанбаатар хотын Хан-Уул, Чингэлтэй, Баянзүрх, Налайх дүүргүүдэд Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Ерөнхий боловсролын сургуулийн өргөтгөл, сургуулийн шинэ барилга барьж, сургалтын орчныг сайжруулна.

2.7.12. Монгол-Японы хамтарсан сургалтын эмнэлэг барих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Япон Улсын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	8.0 тэрбум иен
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	35,293.6 сая төгрөг

Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр АШУИС-ын дэргэдэх Монгол-Японы хамтарсан сургалтын эмнэлгийн барилгын ажлыг хийж гүйцэтгэх бөгөөд 2018 оны 6 сард ашиглалтад хүлээлгэж өгөхөөр ажиллаж байна. Энэхүү төсөл амжилттай хэрэгжсэнээр Анагаахын шинжлэх ухааны салбарын хөгжлийг дэмжээд зогсохгүй, орчин үеийн олон улсын стандартад нийцсэн эмнэлгийн барилга, тоног төхөөрөмжөөр хангагдсан шинэ сургалтын эмнэлэгтэй болох юм.

2.8. САНГИЙН САЙД

2.8.1. Бүс нутгийн хилийн үйлчилгээг сайжруулах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	19.4 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	15,290.8 сая төгрөг

Монгол Улсын Замын-Үүд, Алтанбулаг болон Бичигт хилийн боомтуудын үйл ажиллагааг сайжруулж, Гаалийн автоматжуулсан мэдээллийн системийг шинэчлэн сайжруулах, тус системийг Татварын ерөнхий газрын мэдээлэл, харилцаа холбооны системүүдтэй харилцан ажиллах чадвартай болгож, гадаад худалдааны цахим нэг цонхны системийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангана. Төслийн хүрээнд дараах ажлуудыг хийхээр төлөвлөж байна. Үүнд:

- Замын-Үүд, Алтанбулаг, Бичигтийн хилийн боомтуудын үйл ажиллагааг сайжруулах,
- КАИС-ийг шинэчлэх, мэдээлэл технологийн системүүдийг харилцан ажиллах чадвартай болгох,
- Цахим нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах юм.

2.8.2. Зээлийн баталгааны системийг бүрдүүлэх замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг бий болгох төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл

Санхүүжилтийн нийт хэмжээ	60.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	3,500.0 сая төгрөг

Жижиг дунд үйлдвэр эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлж, уул уурхайн бус салбарууд дахь ажил эрхлэлтийг бий болгох замаар эдийн засгийг төрөлжүүлэхэд оршино.

2.8.3. Төлбөрийн системийн шинэчлэл төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	20.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	7,000.0 сая төгрөг

Төслийн зорилго нь эдийн засаг дахь өсөн нэмэгдэж буй санхүүгийн зах зээлийн хэрэгцээг хангах, улс үндэстнийг бүхэлд нь хамарсан төлбөрийн цогц үйлчилгээг бий болгох, төлбөр түргэн гүйцэтгэх төлбөрийн найдвартай системтэй болох, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэгдэж байна. Төслийн хүрээнд төлбөрийн системийн шинэчлэлийг хийж, техник, тоног төхөөрөмжийг суурилуулах, төлбөрийн системийн дэд бүтцийг сайжруулна.

2.8.4. Хөдөө аж ахуй хөдөөгийн хөгжлийг дэмжих төслийн нэмэлт-Тусгай

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	35.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	32,014.5 сая төгрөг

Агро бизнесийн чиглэлийн хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд хөрөнгө оруулах замаар хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийг дэмжин ажлын байрыг бий болгох, Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэх, ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулахад оршино.

2.8.5. Хөдөө аж ахуй хөдөөгийн хөгжлийг дэмжих төслийн нэмэлт-Энгийн

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	10.7 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	8,860.9 сая төгрөг

Агро бизнесийн чиглэлийн хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд хөрөнгө оруулах замаар хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийг дэмжин ажлын байрыг бий болгох, Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэх, ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулахад оршино.

2.8.6. Тогтвортой амьжиргаа төсөл III - 5487MOG

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Дэлхийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	16.1 сая зээлжих тусгай эрх, 3.3 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2015-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	18,765.2 сая төгрөг гадаад зээл, 1,614.1 сая төгрөг буцалтгүй тусламж

Монгол Улсын хөдөө орон нутагт тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, түүнд засаглал болон иргэд, олон нийтийн оролцоог сайжруулахад чиглэгдсэн.

2.8.7. Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл - 4888MOG

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Дэлхийн банк
---------------------------------	--------------

Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	16.0 сая зээлжих тусгай эрх, 4.2 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2011-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	4,200.0 сая төгрөг гадаад зээл, 397.8 сая төгрөг буцалтгүй тусламж

Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн хөгжлийн зорилт нь санхүүжилтийн эх үүсвэрээс үл хамааран уул уурхайн болон боловсруулах үйлдвэрийг дэмжихийн тулд дэд бүтцийн салбарт хөрөнгө оруулалт хийхийг дэмжих, дэд бүтцийн төслүүдийг боловсруулж, хэрэгжүүлэх дотоод чадавхыг нэмэгдүүлэх.

2.8.8. Экспортыг дэмжих төсөл /ДБ/

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Дэлхийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	14.3 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	14,667.0 сая төгрөг

Төслийн зорилго нь уул уурхайн бус салбар дахь жижиг дунд үйлдвэр эрхлэгч аж ахуй нэгжийн (ЖДААН) экспортын чадавхыг бэхжүүлэх, экспортын зах зээлийг өргөжүүлэх зорилготой.

Монгол Улсын эдийн засгийн уул уурхайн салбараас хамааралтай байдлыг бууруулж эдийн засгаа төрөлжүүлэх, экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх шаардлага бий болоод байгаа билээ. “Экспортыг дэмжих төсөл”-ийг хэрэгжүүлснээр Монгол Улсын хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, гадаад зах зээлд экспортлоход шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох, туршлага судлах, экспортын даатгал гэх мэт санхүүгийн шинэ бүтээгдэхүүнүүдийг бий болгох, санхүүгийн дэмжлэг үзүүлэхээс гадна тодорхой зорилтот зах зээлүүдэд нэвтрэх боломжийг нээх юм.

2.8.9. Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	25.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2022
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	175.1 сая төгрөг

Төсвийн хөрөнгө оруулалт удирдлага, татварын мэдээллийн системийн дэд бүтэц, хяналтын системийг сайжруулахад оршино.

2.8.10. Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг дэмжих төсөл /ДБ/

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Дэлхийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	12.0 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2022
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	6,155.9 сая төгрөг

Төслийн зорилт нь төсвийн болон санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, зарцуулалтын удирдлагын чанарыг сайжруулахад оршино.

2.8.11. БНСУ-ын 500.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх салбарын хөгжлийн хөрөнгө оруулалтын багц төсөл арга хэмжээ

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНСУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	500.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	1,000.0 сая төгрөг

Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газраас авах 500.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр эрүүл мэнд, боловсрол, зам, тээвэр, дэд бүтэц, барилга хот байгуулалт, эрчим хүч, хөдөө аж ахуй байгаль орчны салбарын багц төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

2.8.12. БНХАУ-ын 1 тэрбум ам.долларын үлдэгдэл хөрөнгөөс хэрэгжүүлэх салбарын хөгжлийн багц төсөл, арга хэмжээ

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	233.2 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2022
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	200.0 сая төгрөг

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газраас авах 1.0 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн үлдэгдэл хөрөнгөөс Дэд бүтэц, авто зам, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн салбарын хөгжлийн багц төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

2.8.13. БНХАУ-ын тусламжийн төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	1.0 болон 2.0 тэрбум юань
Төсөл хэрэгжих хугацаа	2015-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	8,904.8 сая төгрөг

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 179 дүгээр тогтоолоор Хятадын талаас шинээр олгох 2 тэрбум юанийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр “Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд хэрэгжүүлэх инженерийн болон нийгмийн дэд бүтэц бүхий бичил дэд төвүүд байгуулах” төслийг хэрэгжүүлэх шийдвэр гарсан.

2.8.14. Дэд бүтэц төсөл - Нүхэн гарц төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	38.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	100.0 сая төгрөг

Нийслэл хотын замын хөдөлгөөний ачааллыг бууруулах үндсэн зорилтын хүрээнд Нийслэлийн Сонгинохайрхан, Хан-Уул, Баянзүрх, Баянгол дүүргүүдэд 9 байршилд авто тээврийн хэрэгсэл зорчих нүхэн гарцыг байгууламж, төмөр замын гармуудад байгуулна.

2.8.15. Дэд бүтэц төсөл - Туул, Сэлбэ гол орчмыг сайжруулах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	57.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	100.0 сая төгрөг

Ногоон Улаанбаатар 2030 хөтөлбөр, Улаанбаатар хотын иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах үндсэн зорилтын хүрээнд Улаанбаатар хотоор дайран урсах Туул, Сэлбэ голын дагуу иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх эко, аюулгүй орчинг бий болгох юм. Үүний дагуу 40 км гаруй дугуйн зам, амралт зугаалгын бүс, Улаанбаатар хотын цэцэрлэгт хүрээлэнг 66 га-аар нэмэгдүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна.

2.8.16. Энэтхэг Улсын 1 тэрбум ам.долларын экспортын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНЭУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл

Санхүүжилтийн нийт хэмжээ	1.0 тэрбум ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2022
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	8,756.3 сая төгрөг

Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газраас авах 1.0 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр Газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулахаар төлөвлөж байна. Төслийн ТЭЗҮ-ийг

2.8.17. Экспортын зээлийн шугам JBIC-CLA

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Япон Улсын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	10.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	19,310.1 сая төгрөг

Төслийн зорилго нь Монгол Улсын Засгийн газар, Японы Олон улсын хамтын ажиллагааны банк хооронд байгуулах экспортын зээлийн ерөнхий хэлэлцээрийн төслийн хүрээнд зээлийн шугам нээж, зээлийн эх үүсвэрийг дотоодын арилжааны банкаар дамжуулан дотоодын үйлдвэрлэгч, аж ахуйн нэгжээс гаргасан төслийн хүсэлт дээр нь үндэслэн тэдгээрийн бизнесийг өргөжүүлэхэд шаардлагатай экспортын зээл олгох замаар үйлдвэрлэлийг дэмжиж, эдийн засгийн өсөлтийг сайжруулахад оршино.

2.9. ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД

2.9.1. Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх 2 дахь шатны төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	125.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2014-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	14,000.0 сая төгрөг

Монгол Улсын баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын нийт урт нь БНХАУ-тай хил залгаа Ярантын хилийн боомтоос ОХУ-тай хил залгаа Улаанбайшинтын хилийн боомт хүртэл 743.1 км бөгөөд энэхүү коридор нь Монгол Улсыг баруун бүсийн Ховд, Баян-Өлгий аймгаар БНХАУ-ын Шинжаань бүс, ОХУ-ын Сибирийн бүстэй холбох Азийн авто замын АН-4, CAREC-ийн коридор 4"а" чиглэлийн нэг хэсэг юм. Энэхүү коридорыг Монгол Улсын болон Азийн авто замын төлөвлөлтийн стандартыг хангахуйц асфальт бетон хучилттай авто замаар бүрэн холбосноор Монгол Улсын эдийн засгийн тогтвортой хөгжил, дотоодын зах зээлийг дэмжиж, улмаар дамжин өнгөрөх ачаа, зорчигч тээвэрлэлтийг хөгжүүлэхэд чиглэгдсэн Монгол Улсын тээврийн стратегийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой болно.

2.9.2. Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	25.4 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2011-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	3,500.0 сая төгрөг гадаад зээл, 920.4 сая төгрөг буцалтгүй тусламж

Төслийн зорилго нь Мянганы хөгжлийн зорилтуудыг хангах таатай нөхцөлийг бүрдүүлэх, гадаадаас Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээвэрлэлтийг нэмэгдүүлж, үр ашгийг дээшлүүлэхэд оршино. Мөн Замын-Үүд боомтод үр ашигтай, өрсөлдөхүйц, найдвартай холимог тээврийн системийг хөгжүүлэх ложистикийн төвийг байгуулах зорилготой болно.

2.9.3. Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км авто зам барих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	59.8 сая ам.доллар

Төсөл хэрэгжих хугацаа	2016-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	44,136.2 сая төгрөг

Хөдөө аж ахуйд суурилсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлд хөрөнгө оруулалт хийх, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, зах зээлд нийлүүлэх чадварыг нэмэгдүүлэх замаар хөдөөгийн хүн амын амьжиргааг сайжруулж, хүнсний аюулгүй байдлыг хангах явдал юм. Энэ хүрээнд Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км авто зам, Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км авто зам, ажил хийгдэж, энэ нь баруун бүсийн эдийн засгийн хөгжилд томоохон түлхэц үзүүлэх ач холбогдолтой юм.

2.9.4. Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км авто зам барих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	44.4 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	39,287.4 сая төгрөг

Хөдөө аж ахуйд суурилсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлд хөрөнгө оруулалт хийх, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, зах зээлд нийлүүлэх чадварыг нэмэгдүүлэх замаар хөдөөгийн хүн амын амьжиргааг сайжруулж, хүнсний аюулгүй байдлыг хангах явдал юм. Энэ хүрээнд Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км авто зам, Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км авто зам, ажил хийгдэж, энэ нь баруун бүсийн эдийн засгийн хөгжилд томоохон түлхэц үзүүлэх ач холбогдолтой юм.

2.9.5. Улаанбаатар-Хөшигийн хөндий шинэ нисэх онгоцны буудлын хурдны зам барих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	147.5 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	74,204.7 сая төгрөг барилга угсралт, 3,321.8 сая төгрөг зөвлөх

Улаанбаатар-Хөшигийн хөндий олон улсын шинэ нисэх онгоцны буудал ашиглалтад орж байгаатай холбогдуулж, энэ чиглэлийн 32.5 м өргөн асфальт бетон хучилттай зорчих хэсэгтэй, 2 урсгал 6 эгнээтэй олон улсын стандартад нийцсэн хурдны авто замыг ашиглалт оруулж, авто замын сүлжээг нэмэгдүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг бий болгоход төслийн зорилго оршино.

2.9.6. Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудал барих төсөл – нэмэлт санхүүжилт /MON-P12/

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Япон Улсын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	35.3 тэрбум иен
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	134,602.8 сая төгрөг

Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг барьж, улмаар Чингис Хаан олон улсын нисэх онгоцны буудлын үйлчилгээнд тулгарч буй хүндрэлийг арилгах, агаарын тээврийн салбарын хөгжлийг эрчимжүүлэхэд төслийн зорилго оршино.

2.9.7. Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, зам засварын төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	60.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2022
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	3,502.5 сая төгрөг

Зам засвар, шинэчлэлийн ажлыг хийж, замын аюулгүй байдлыг хангах, замын хөрөнгийн удирдлагын чадавх, хэрэгжилтийг сайжруулахад чиглэнэ.

2.9.8. Авто замын байгууламжийн нэмэлт материалын үйлдвэр байгуулах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Польш Улсын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	5.1 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	7,477.3 сая төгрөг

Энэхүү төслийн хүрээнд Авто замын байгууламжийн “Дуосолид” нэмэлт бүтээгдэхүүний үйлдвэр байгуулах бөгөөд уг бүтээгдэхүүнийг шавар, холимог, хайрга дайраг болон холимог хөрсийг сайжруулж илүү тогтвортой болгох, Эрдэст-асфальт хучилтын доор шууд тавигдах, холимог хөрсөөр нэмэлт давхарга хийх, эх хөрсийг эсвэл ухмал хөрсийг сайжруулах, хүчитгэх, тогтворжуулах зориулалтаар төмөр замын суурь барих, мөн хамгаалалт аюулгүй байдлыг хангах элементүүдийг хүчитгэх, төмөр замын дээд хэсэгт хэрэглэгддэг хамгаалалтыг далдлах, хуучин замыг сэргээн засварлахад хуучин асфальт бетон хучилтыг хольж нийлүүлэн ашиглаж дахин суурийн давхарга хийж дээр нь шинэ эрдэст-асфальт бетон давхарга болгох зориулалттай.

2.9.9. Улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээ-2

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНСУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	30.5 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	24,549.9 сая төгрөг

Улс хот хоорондын нийтийн тээврийн паркийг шинэчлэхэд шаардагдах бараа, материал, тоног төхөөрөмж, автобус нийлүүлэгдэнэ.

2.9.10. Улиастай-Тосонцэнгэл чиглэлийн 67 км автозам барих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	24.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	5,000.0 сая төгрөг

Шинэ бүтээн байгуулалт, дунд хугацааны зорилтот хөтөлбөр" болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбох зорилтын дагуу Улиастай-Тосонцэнгэл чиглэлийн Загастайн давааны 67км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөөд байна.

2.10. ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

2.10.1. Төрийн тусгай албан хаагчдыг нэгдсэн эмнэлэг төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Австри Улсын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	7.0 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	7,169.6 сая төгрөг

Төрийн Тусгай Албан Хаагчдын Нэгдсэн Эмнэлэг (ТТАХНЭ)-ийн багаж, тоног төхөөрөмжийг шинэчлэх, суурилуулах, хүний нөөцийг бэлтгэх төсөл нь үйлчлэх хүрээний иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, эмч, мэргэжилтнийг чадваржуулахад чухал ач холбогдолтой төсөл болно. Төслийн хүрээнд эмнэлгийн тоног, төхөөрөмж суурилуулагдаж, эмч, мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлнэ.

2.10.2. Эрхзүйн шинэчлэл багц төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНСУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	44.0 сая ам.доллар

Төсөл хэрэгжих хугацаа	2017-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	3,502.5 сая төгрөг

Хууль сахиулах байгууллагуудын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах, гэмт хэрэг зөрчилд тавих цахим хяналтын тогтолцоог бүрдүүлэх, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх, хууль зүйн салбарын материаллаг бааз, хүний нөөцийг бэхжүүлэхэд оршино.

Төслийн хүрээнд 1) Архивын ерөнхий газрын шинэ цогцолбор барилгад архивын баримтын хадгалалт, хамгаалалт, сэлбэн засах, сэргээн шинэтгэх; мэдээллийн технологи; кино, гэрэл зураг, дуу авианы баримтын хадгалалт, цахим хэлбэрт шилжүүлэх; архивын баримтыг микрофильмд буулгах зэрэг үйл ажиллагаанд шаардагдах орчин үеийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл суурилуулж, ашигласнаар үндэсний архивын үйл ажиллагааг сайжруулах, иргэдэд түргэн шуурхай үйлчилгээг хүргэх; 2) ШШҮХ-ийн барилга байгууламжийг орчин үеийн стандарт нийцүүлэн өргөтгөн тохижуулж, гэмт хэргийг илрүүлэхэд шаардлагатай орчин үеийн олон улсын стандартад нийцсэн тоног төхөөрөмжөөр хангах, шүүх шинжилгээ хийх чадамжийг сайжруулах; 3) Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь “Гэрийн хорионд байлгах” ял эдлүүлэлтэнд хяналт тавих “Хяналтын төв”-ийг байгуулах, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл суурилуулж, хяналтын тогтолцоог бүрдүүлэх; 4) Хууль сахиулах их сургуулийн зорилго нь үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй агентлаг байгууллагуудын үйл ажиллагааг боловсронгуй болгон хөгжүүлэх чиглэлээр хууль зүй болон цэргийн шинжлэх ухааны хүрээнд судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулж, сургалтын материаллаг баазыг бэхжүүлж, захиалагч байгууллагуудын эрэлт хэрэгцээнд нийцсэн хүний нөөцийг бэлтгэх, тэднийг мэргэшүүлэх, сургалтын чанар, орчныг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн сайжруулах, суралцагч, багш, албан хаагч нарт сурч ажиллах таатай орчин нөхцөл бүрдүүлэх юм.

2.10.3. Улаанбаатар хот, аймгийн төвийн гудамж талбайг камержуулах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	28.3 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	100.0 сая төгрөг

Төслийн зорилго нь иргэдийн аюулгүй, таатай орчинд амьдрах үндсэн зорилтын хүрээнд Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн төвүүдийн зам, гудамж, талбайн камерын хяналтын цэгийг нэмэгдүүлж, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, бүтээмжийг дээшлүүлэхэд оршино.

2.11. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД

2.11.1. Хөдөө аж ахуйн маркетинг төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Дэлхийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	11.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2013-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	1,039.4 сая төгрөг

Мал аж ахуйд суурилсан үйлдвэрлэлийн бүтээмжийг сайжруулах, зэх зээлтэй холбох, нэр төрлийг нэмэгдүүлэхэд хөрөнгө оруулах замаар хөдөөгийн хүн амын амьжиргааг сайжруулж, хүнсний аюулгүй байдлыг хангах.

2.11.2. Хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих замаар амьжиргааг сайжруулах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	3.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	375.3 сая төгрөг

Уг буцалтгүй тусламжийн үндсэн зорилго нь хүнсний ногоо болон үрийн аж ахуйн үр өгөөжийг сайжруулах замаар орлогын эх үүсвэрийг бий болгох, хүнсний нэр төрлийг нэмэгдүүлж хөдөөгийн хүн ам,

ялангуяа 5 га хүртэлх газар эзэмшдэг жижиг фермерүүд болон хоршоологчдын амьжиргааг дэмжихэд оршино. Санал болгож буй буцалтгүй тусламж нь импортын хүнсний ногоо болон үрийн хэрэглээг бууруулах Засгийн газрын үйл ажиллагааг дэмжих юм.

2.11.3. Хөдөө аж ахуйн машин, трактор угсрах үйлдвэр байгуулах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНПУ-ын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	32.0 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	5,000.0 сая төгрөг

Хөдөө аж ахуйн зориулалт бүхий Трактор угсрах үйлдвэр барих, дотооддоо трактор угсарч, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний өртөг бууруулах, улс орны эдийн засагт дэмжлэг үзүүлэх, баялаг бүтээх, ажлын байр нэмэгдүүлэхэд төслийн зорилго оршино.

2.11.4. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл - нэмэлт санхүүжилт

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	9.1 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	4,378.2 сая төгрөг

Хөдөөгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг тогтвортой дээшлүүлэх, Монгол улсын засгийн газрын “Монгол Мал” Хөтөлбөр, “Хоршооллыг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэхэд төслийн зорилго оршино.

2.11.5. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	24.5 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	5,000.0 сая төгрөг

Төслийн хүрээнд худалдаж авах техник нь үр тариа, таримал тэжээлийн үйлдвэрлэлд нэн шаардлагатай байгаа дундаас дээш хүчин чадалтай трактор юм. Энэхүү техник, тоног төхөөрөмжийг тодорхой хувийн урьдчилгаатай, үлдэгдэл төлбөрийг урт хугацаатай зээлээр олгох нөхцөлөөр худалдан борлуулахаар төлөвлөж байна. Энэхүү төслийг хэрэгжүүлснээр үр тарианы үйлдвэрлэл эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжид техникээ шинэчлэхэд томоохон дэмжлэг болно.

2.11.6. Газар тариалангийн үйлдвэрлэлд хөрс хамгаалах, өндөр хүчин чадлын технологийг нэвтрүүлэх төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	20.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	100.0 сая төгрөг

Дэвшилтэт техникүүдийг газар тариалангийн үйлдвэрлэлд нэвтрүүлснээр атар газар эзэмшсэнээс хойш ашиглаж ирсэн хуучин технологийг халж, буруу ашиглалтаас болж жил бүр салхинд хийсгэж буй шим тэжээлт хөрсийг хамгаалж, бүтээмжийг нэмэгдүүлэн зардлыг бууруулж бүтээгдэхүүний гарцыг тогтмол болгох нь энэхүү төслийн зорилго болно.

Төслийн хүрээнд дунд, том оврын трактор болон дунд, том оврын комбайн, өөрөө явагч хор цацагч тус тус нийлүүлэгдэнэ.

2.12. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД

2.12.1. Хөдөлмөр эрхлэлтийн ур чадварыг сайжруулах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	17.0 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2015-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	2,800.0 сая төгрөг

Мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог эрэлтэд нийцүүлэн хөгжүүлэх замаар хөдөө аж ахуй, барилга, зам тээврийн салбарт МБСБ төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн ур чадварыг дээшлүүлэхэд оршино

2.12.2. Хүнс гэжээл, нийгмийн халамжийн төсөл-Нэмэлт санхүүжилт

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	13.0 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2014-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	2,800.0 сая төгрөг

Төслийн зорилго нь төрийн бодлого, систем болон мэдээллийн технологийг бэхжүүлэх замаар нийгмийн халамжийн болон даатгалын үйлчилгээг үр ашигтай, ил тод байдлаар хүргэхэд оршино.

2.12.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв барих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	181.6 сая юань
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	1,858.1 сая төгрөг

Төслийн хүрээнд Баянгол дүүргийн 20 дугаар хороонд нийт 14990 м2 талбайтай нөхөн сэргээлт хөгжлийн төв, туслах багажийн төв, цайны газар, ажлын өрөө, сургалтын өрөө танхим болон стандарт эмчилгээний өрөө бүхий Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийг барьж байгуулна.

2.12.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүрэх үйлчилгээг сайжруулж, оролцоог нэмэгдүүлэх төсөл /АХБ/

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	25.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	4,378.2 сая төгрөг

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүрэх үйлчилгээг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, мөн тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, оролцоог нэмэгдүүлэх, өөрөөр хэлбэл бие даах чадвар, нийгэм, эдийн засагт тэдний оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхэд оршино.

2.12.5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Дэлхийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	18.4 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2022
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	6,155.9 сая төгрөг

Ажилгүйдлийг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилготой. Хөдөлмөрийн зах зээлийг хөгжүүлэх, төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чанар, ил тод байдлыг сайжруулах замаар иргэдийн ажилд орох боломжийг нэмэгдүүлж, хөдөлмөрийн зах зээлийг хөгжүүлэхэд оршино.

2.12.6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай тоноглол бүхий спорт цогцолбор барих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	20.4 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	7,655.5 сая төгрөг

Төслийн хүрээнд олон улсын стандартын шаардлага хангасан, тамирчдын физик эмчилгээний өрөө бүхий хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглон спорт цогцолборыг барьж байгуулна.

2.13. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

2.13.1. Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4 төсөл – MON0236

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	14.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2011-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	1,889.9 сая төгрөг

Эмнэлгийн салбарыг хөгжүүлэх, салбарын үр ашиг, засаглал, эмийн аюулгүй байдлыг сайжруулахад чиглэгдэж байгаа бөгөөд төсөл дараах 3 бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хэрэгжиж байна. Үүнд:

- Эмнэлгийн тусламж үйлчилгээг бэхжүүлэх,
- Хүний нөөцийн хөгжлийг сайжруулах,
- Эмийн аюулгүй байдлыг сайжруулах зэрэг орно

2.13.2. Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-4 нэмэлт санхүүжилт

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	16.2 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2011-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	3,507.4 сая төгрөг

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн эмнэлгийг Улаанбаатар хотын бусад дүүрэгт загвар болохуйц, олон төрлийн тусламж, үйлчилгээтэй нэгдсэн эмнэлэг болгон өөрчлөх, ингэхдээ мэс засал, эхийн эрүүл мэндийн үйлчилгээг нэмэх, оношилгоо, лабораторийн хүчин чадлыг сайжруулах, амбулаторийн болоод хэвтэн эмчлүүлэх хэсгийн нэгдсэн удирдлага менежмент, сувилгааны загвар тусламж үйлчилгээ, эмнэлгийн хог хаягдлын боловсруулалт, халдвараас урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээнүүд, өвчтөн, санхүүгийн удирдлагад зориулсан технологийн хэрэгслүүд зэргийг боловсронгуй болгоход оршино.

2.13.3. Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5 төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	19.5 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2013-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	2,800.0 сая төгрөг

Эрүүл мэндийн салбарын хөгжлийн дэмжих, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулах, улсын хэмжээнд цусны аюулгүй байдлыг бэхжүүлэх, эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах, эрүүл мэндийн байгууллагын эрүүл ахуй, халдварын сэргийлэлт хяналтыг бэхжүүлэхэд оршино.

2.13.4. Баруун бүсийн оношилгоо, эмчилгээний төв байгуулах төсөл - Бельги Улсын зээлийн төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Бельги Улсын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл

Санхүүжилтийн нийт хэмжээ	4.6 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	4,410.0 сая төгрөг

Бүс нутгийн эрүүл мэндийн салбарын хөгжлийг дэмжих зорилгоор Баруун бүсийн оношилгоо, эмчилгээний төвд дэвшилтэт оношилгооны тоног төхөөрөмжийг нийлүүлж, эмч мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэх, баруун бүсийн иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулахад оршино.

2.13.5. Цахим эрүүл мэнд төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Дэлхийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	12.7 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2015-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	9,192.0 сая төгрөг

Эрүүл мэндийн байгууллагуудын бизнесийн үйл ажиллагаа, мэдээллийн урсгалын дүн шинжилгээ хийж эрүүл мэндийн мэдээллийн технологийн энтерпрайз архитектур бий болгон хөгжүүлнэ.

2.13.6. Түлэнхийн төв барих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Кувейтийн Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	8.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	125.1 сая төгрөг

Монгол Улсын хэмжээнд түлэгдэлт, хөлдөлт, нөхөн сэргээх мэс заслын төрөлжсөн нарийн мэргэжлийн үйлчилгээг цогц байдлаар үзүүлэх, олон улсын чанар стандартад бүрэн нийцүүлэх, орчин үеийн оношилгоо эмчилгээний багаж тоног төхөөрөмжөөр иж бүрэн тоноглох, ард иргэдийн эрүүл мэндийг чандлан сахихад өндөр ач холбогдолтой.

2.13.7. Үндэсний оношлогоо, эмчилгээний төв байгуулах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНСУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	65.0 тэрбум вон
Төсөл хэрэгжих хугацаа	2013-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	49,938.9 сая төгрөг

Хүн амын өсөлттэй холбогдон гарч буй бодит эрэлтэд тулгуурлан олон нийтэд эрүүл мэндийн үйлчилгээ, эмчилгээ, оношилгооны боломжит, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх, гадаадад эмчлүүлэхээр явж буй өвчтөнүүдийн тоо болон эрүүл мэндийн нийт зардлыг бууруулах, орон нутгийн болон эрүүл мэндийн үйлчилгээ дутагдалтай газар илүү хүртээмжтэй эрүүл мэндийн үйлчилгээг бий болгох, оношилгооны алдаанаас үүдэн гарах нас баралтын хэмжээг бууруулах зорилготой.

2.13.8. Гэмтэл согог судлалын үндэсний төвийн хүлээн авах, яаралтай тусламжийн тасгийн тусламж үйлчилгээг сайжруулах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНФУ-ын Засгийн газар – Натиксис банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	5.0 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2013-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	194.7 сая төгрөг

Улсын хэмжээнд осол гэмтлийн эмчилгээ үйлчилгээ үзүүлдэг төв эмнэлгийн хүлээн авах яаралтай тусламжийн үйлчилгээний зохион байгуулалт, чанарыг нэмэгдүүлж, улмаар нас баралт болон хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулахад чиглэгдэж байна.

2.13.9. Цахим эрүүл мэнд төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	18.9 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2015-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	3,352.5 сая төгрөг

Эрүүл мэндийн салбарын мэдээллийн технологийн дэд бүтцийг шинэчилж шаардлагатай тоног төхөөрөмжөөр болон программ хангамжийг нийлүүлэх бөгөөд төслийн хүрээнд 14.8 сая ам долларын тоног төхөөрөмж (Үүнд: 7000 ширхэг компьютер, сервер, UPS, Diesel генератор, IT&IP төхөөрөмж, агааржуулагч, принтер, сканер болон принтер), 4.1 сая ам.долларын программ хангамж (үүнд: цахим-эмнэлэг програм хангамж, цахим-эмнэлэг цогц загвар, цахим-эмнэлэг програм хангамжийн инженерчлэл, сургалт) ажлууд хийгдэнэ. Програм хангамж нь Эрүүл мэндийн яамны харьяа эмнэлэг-12, аймгийн нэгдсэн эмнэлэг-21, дүүргийн нэгдсэн эмнэлэг-9, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг-6 тус тус суугдана.

2.13.10. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн тоног төхөөрөмжийг шинэчлэх -2 шат” төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Австри Улсын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	7.0 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	7,169.6 сая төгрөг

Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн оношилгоо, эмчилгээний чадавхыг бүрэн сайжруулснаар эх, эмэгтэйчүүд, хүүхдэд үзүүлж буй гуравдах шатлалын лавлагаа тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна. Төслийн хүрээнд оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмж суурилуулах, эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн тоног төхөөрөмжийн ажилтнуудын чадавхыг сайжруулах, шинэ технологи ашиглахтай холбоотой сургалтуудыг зохион байгуулна.

2.13.11. Эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	50.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	6,254.5 сая төгрөг

Өрх сумын эрүүл мэндийн төв лабораторийг сэргээн засах эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангах, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, анхан шатны түргэн тусламж үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний нэр төрөл, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой.

2.14. ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД

2.14.1. Дарханы дулааны цахилгаан станцын турбины шинэчлэл, нэмэлт санхүүжилт төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	ХБНГУ-ын Засгийн газар - KfW
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	4.5 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	8,193.8 сая төгрөг

Дархан-Уул аймгийн төв Дархан сумыг дулааны эрчим хүчээр найдвартай хангах, өсөн нэмэгдэж буй цахилгаан дулааны эрчим хүчний хэрэглээг хангахад орших бөгөөд төслийн хүрээнд үйлдвэрлэгдэж нийлүүлэгдсэн үндсэн тоног төхөөрөмжүүдийг (ПТ-35/39-3,4/1,0 маркийн уурын турбин, Т-35-2У3 маркийн турбогенератор) угсарч суурилуулах, туршиж тохируулах, ажилд залгах, дутуу хийгдсэн барилга угсралтын ажлуудыг дуусгах, шинээр эргэлтийн усны шугам хоолой татах, цахилгаан хуваарилах байгууламж өргөтгөх, шинээр цахилгаан болон механик тоног төхөөрөмжүүдийг худалдан авах гэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэх болно.

2.14.2. Эрчим хүчний системийн үр ашиг төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	ХБНГУ-ын Засгийн газар - KfW
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	3.0 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	850.0 сая төгрөг

Эрчим хүчний үр ашгийг дэмжих замаар эрчим хүчний үйлдвэрлэл ба хэрэглээг эдийн засаг, экологийн хувьд тогтворжуулж, эрчим хүчний найдвартай хангамжийг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулах явдал юм. Төслийн хүрээнд холбогдох хууль, дүрэм журмуудыг боловсруулах, шаардлагатай программ хангамж, мэдээллийн баазаар холбогдох байгууллагуудыг хангах зорилт тавин ажиллаж байна.

2.14.3. Улаанбаатар хотын Дөрөвдүгээр цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төсөл, MON-P10 /JICA/

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Япон Улсын Засгийн газар - ЯОУХААБ
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	4.0 тэрбум иен
Төсөл хэрэгжих хугацаа	2014-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	18,909.0 сая төгрөг

Эрчим хүч, дулаан үйлдвэрлэхэд шаардагдах нүүрс, дизель түлшний хэмжээг тодорхой төвшинд хэмнэх нөхцөлийг бүрдүүлэх, IV цахилгаан станцын дулааны болон эрчим хүчний үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлж, тулгамдаж буй эрчим хүчний дутагдлыг багасгах, иргэд болон аж ахуйн нэгжүүдийг тогтвортой, найдвартай эрчим хүчээр хангахад чухал хувь нэмэр оруулахад төслийн зорилго оршино.

2.14.4. Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	40.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2022
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	87.6 сая төгрөг

Монгол улсын Баруун бүсийн эрчим хүчний системд 25МВт нар, салхины эх үүсвэрийг суурилуулан алслагдсан бүс нутагт сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх, сэргээгдэх эрчим хүчний зохицуулалтын хүрээнд боловсон хүчний чадамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрөөр дамжуулан их чадлын сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт оруулах хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжихэд оршино.

2.14.5. Дулааны цахилгаан станцын шинэчлэл төсөл /ХБНГУ/ Дархан

Санхүүжүүлэгч байгууллага, орон	ХБНГУ-ын Засгийн газар - KfW
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	5.0 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	2,048.5 сая төгрөг

Дархан хотыг дулааны эрчим хүчээр найдвартай тасралгүй хангах, өсөн нэмэгдэж буй дулааны эрчим хүчний хэрэглээг тус тус хангах зорилгоор Дулааны цахилгаан станцад шаардлагатай тоног төхөөрөмжийг шинэчлэх юм. Энэхүү төсөл хэрэгжсэнээр Дархан хотын дулааны эрчим хүчний эх үүсвэр 25 жилийн хугацаанд найдвартай ажиллах болно.

2.14.6. Эрчим хүчний дамжуулах сүлжээний үр ашгийг дээшлүүлэх (дэд станцууд) /ХБНГУ/

Санхүүжүүлэгч байгууллага, орон	ХБНГУ-ын Засгийн газар - KfW
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	20.4 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	4,189.1 сая төгрөг

Төвийн эрчим хүчний системийн 1960-1970 онд суурилагдсан 110, 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцад суурилагдсан тоног төхөөрөмж, тоноглолыг шинэчилж төвийн эрчим хүчний системийн найдвартай ажиллагааг хангах, алдагдлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ.

2.14.7. Сэргээгдэх эрчим хүчний төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Дэлхийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	12.4 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	1,876.4 сая төгрөг

Төслийн зорилго нь Монгол Улсын эрчим хүчний салбарын хөгжлийг эрчимжүүлэх, нэн ялангуяа сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх, эрчим хүчний үйлчилгээний найдвартай байдлыг сайжруулахад оршино.

2.14.8. Эрчим хүчний салбарын төсөл - 2

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Дэлхийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	30.7 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2022
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	4,455.9 сая төгрөг

Төслийн зорилго нь Монгол Улсын цахилгаан, эрчим хүчний үйлчилгээний найдвартай, тогтвортой байдлыг сайжруулах явдал юм. Төсөл нь 3 бүрэлдэхүүн хэсэгтэй бөгөөд эрчим хүчний түгээлтийн сүлжээг шинэчлэх, 10 МВт-ийн нарны эрчим хүчний эх үүсвэрийг байгуулах, эрчим хүчний салбарын мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэхэд оршино.

2.14.9. 10 аймгийн төвийн дулааны станц барих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНСУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	130.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2022
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	175.1 сая төгрөг гадаад зээл, 1,289.7 сая төгрөг гадаад тусламж

Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говь Сүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Төв, Сүхбаатар аймгуудын төвийн дулааны станцтай төвлөрсөн дулаан хангамжийн системд шилжүүлэн техник, технологийн шинэчлэлт хийх, оршин суугчдыг найдвартай халаалт, хэрэглээний халуун усаар тогтмол хангах, ая тухтай, эрүүл орчныг бүрдүүлэхэд оршино.

2.14.9. Улаанбаатар-Мандалговь цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	113.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	78,811.4 сая төгрөг гадаад зээл

Улаанбаатар-Мандалговийн 330 кВ-ын овортой 2 хэлхээт 260 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 220 кВ-ын дэд станц барих бөгөөд төслийг хэрэгжүүлснээр Монгол Улсын нийгэм, эдийн засагт ихээхэн хувь нэмэр оруулах томоохон ашигт малтмалын орд газрууд болох Таван толгой, Оюутолгой болон Цагаансуврагийн цахилгаан эрчим хүчний үе шатны хэрэглээг төвийн эрчим хүчний системээс найдвартай хангах, мөн Таван толгой цахилгаан станц ашиглалтад ороход 2 талын эх үүсвэртэй бүс хоорондыг холбосон чухал ач холбогдолтой цахилгаан дамжуулах агаарын шугамыг бий болгох юм.

2.14.10. Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын шинэчлэл төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
--	-------------------------------------

Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	49.2 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	3,000.0 сая төгрөг гадаад зээл

Төслийн зорилго нь Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 35 МВт-аар өргөтгөж, эрчим хүчний өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангахад оршино. Төслийн хүрээнд СС-50 турбогенератор шинээр суурилуулж, хими ус цэвэрлэгээний тоног төхөөрөмжийг шинэчилж, эсрэг осмосын технологид шилжүүлэх, сүлжээний групп бойлер шинээр суурилуулах, хөргөх цамхаг шинээр барих, 3 км агаарын шугам, ил, далд хуваарилах байгууламж, трансформатор, цахилгаан удирдлага, хамгаалалт, автоматик, тоног, төхөөрөмжүүдийн хамт суурилуулагдана.

2.15. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР

2.15.1. Цахим сургалт төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	800.0 мянган ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	300.2 сая төгрөг

Прокурорын ерөнхий газрын нийт албан хаагчдад зориулсан сургалтын анги танхим, аудио хичээлийн тоног төхөөрөмжөөр хангах зорилготой.

2.16. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

2.16.1. Үндэсний аудитын газрын чадавх бэхжүүлэх төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Дэлхийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	380.0 мянган ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	87.6 сая төгрөг

Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэж байгаа санхүүгийн аудитын арга зүй, стандартад үнэлгээ хийлгэх, төрийн аудитын ажилтнуудын мэргэжлийн тасралтгүй сургалтын хөтөлбөр боловсруулах болон хувийн аудитын компанитай гэрээлэх, тэдгээрт хяналтыг сайжруулах замаар төрийн аудитын чадавхыг бэхжүүлэхэд оршино.

2.17. ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА

2.17.1. Үндэсний статистикийн хорооны чадавхыг бэхжүүлэх төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Дэлхийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	480.0 мянган ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	24.4 сая төгрөг

Үндэсний статистик мэдээлэл тархалтын чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор Үндэсний статистикийн хороо, нэн ялангуяа орон нутгийн статистикийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх замаар үндэсний хэмжээний тоо, мэдээллийн чанарыг сайжруулах, улмаар олон улсын статистикийн стандарт, аргачлалыг нэвтрүүлж, үндэсний статистикийн хорооны чадавхыг бэхжүүлэхэд оршино.

2.18. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА

2.18.1. Усны шугам сүлжээг шуудуу ухалгүйгээр сэргээн засварлах технологи нэвтрүүлэх төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Австри Улсын Засгийн газар
--	----------------------------

Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	7.0 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	12,172.4 сая төгрөг

Улаанбаатар хотын цэвэр, бохир усны шугам сүлжээ нь 1950-аад оноос эхлэн ашиглалтад орсон, 30-50 жилийн насжилттай учир хуучирч, их хэмжээний зэврэлт үүссэн ундны усны шугам сүлжээг дэлхийн олон оронд дэлгэрсэн бага зардлаар ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг сэргээн сайжруулах шинэ технологийг нэвтрүүлэх замаар шугам хоолойн насжилтыг уртасгах, шугам сүлжээнд гарах урсгал зардлын хэмжээг бууруулах, энэ чиглэлийн мэргэжлийн нэгж бий болгох, шинэ төрлийн мэргэжлийн боловсон хүчнийг сургаж бэлтгэх юм.

Зээлийн хөрөнгөөр Улаанбаатар хотын Ус хангамжийн шугам сүлжээг шуудуу ухалгүйгээр сэргээн сайжруулах технологийг нэвтрүүлэхэд шаардлагатай иж бүрэн тоног төхөөрөмж, нийт 44 км шугам, хоолой доторлох түүхий эд материал, технологи дамжуулах, мэргэжилтэн бэлтгэх иж бүрэн сургалт зэргийг авна.

2.18.2. Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	29.7 сая ам.доллар, 19.8 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2015-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	2,100.0 сая төгрөг гадаад зээл, 159.1 сая төгрөг тусламж

Босоо тэнхлэгийн дагуу 7.7 км замыг сайжруулах, Энхтайвны гүүрний өргөтгөлийн ажил, Босоо тэнхлэгийн дагуу тусгай замын автобусны 14 км шугамын барилгын ажил, Босоо тэнхлэгийн дагуу цахилгаан тээврийн хэрэгслийн 14 км замын дэд бүтцийг сайжруулах ажил, автобусны байршил тогтоох удирдлагын системийг нэвтрүүлэх юм.

2.18.3. Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	27.5 сая ам.доллар, 14.5 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2012-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	3,150.0 сая төгрөг гадаад зээл, 1,379.4 сая төгрөг тусламж

Улаанбаатар хотын хөрс агаарын бохирдлын үндсэн эх үүсвэрийг бий болгож буй хотын хойд хэсэгт байрлах Баянхошуу болон Сэлбэ, Долоон буудлыг сонгон авч инженерийн дэд бүтцээр бүрэн хангагдсан, амьдралын таатай орчныг бүрдүүлэх хотын дэд төвүүдийг бүтээн байгуулахад оршино.

2.18.4. Улаанбаатар хотын цэвэр агаар төсөл /ДБ/

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Дэлхийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	9.7 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2012-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	2,426.1 сая төгрөг

Төслийн зүгээс агаарын бохирдлыг бууруулах богино болон дунд хугацааны арга хэмжээг хэрэгжүүлж, боловсруулахад дараах гурван чиглэлээр дэмжлэг үзүүлнэ. Үүнд: (а) гэр хорооллын орчинд нарийн ширхэгт тоосонцрын агууламжийг бууруулахын тулд сайжруулсан зуухны хөтөлбөр хэрэгжүүлэх; (б) Улаанбаатар хотын төвийн бүсэд нарийн ширхэгт тоосонцрын агууламжийг багасгах зорилгоор үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлэх болон тэргүүлэх ач холбогдол бүхий бодлогын зөвлөмжүүд боловсруулах; (в) Олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, хөтөлбөрийн уялдаа холбоог хангах. УБЦАТ нь агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрүүдийн орхигдсон орон зайг нөхөх зорилгыг мөн агуулж байна. Өмнөх хөтөлбөрүүдийн орон зайг нөхөх энэхүү үйл ажиллагааны чухал элемент нь дотоодын зуух үйлдвэрлэгч/ханган нийлүүлэгчдийг цаашид цэвэр технологийн зуух нийлүүлэх, зуухны борлуулалтын дараах үйлчилгээг хариуцах чадавхыг хөгжүүлэхэд оршино.

2.18.5. Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл /Европын хөрөнгө оруулалтын банк/

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Европын хөрөнгө оруулалтын банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	50.0 сая евро
Төсөл хэрэгжих хугацаа	2012-2022
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	4,096.9 сая төгрөг

Улаанбаатар хотын хөрс агаарын бохирдлын үндсэн эх үүсвэрийг бий болгож буй хотын хойд хэсэгт байрлах Баянхошуу болон Сэлбэ долоон буудлыг сонгон авч инженерийн дэд бүтцээр бүрэн хангагдсан, амьдралын таатай орчныг бүрдүүлэх хотын дэд төвүүдийг бүтээн байгуулахад оршино.

2.18.6. Замын цагдаагийн газрын ойролцоох гүүрэн гарц төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	42.4 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	14,687.5 сая төгрөг

Улаанбаатар хотыг хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний дагуу Улаанбаатар хотын авто замын сүлжээг өргөтгөж, замын хөдөлгөөний ачааллыг бууруулж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах зорилготой.

2.18.7. Яармагийн шинэ гүүр барих, хуучин гүүрийг засварлах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	30.3 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2018
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	11,197.3 сая төгрөг

Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага баримт бичигт тусгагдсаны дагуу хөдөлгөөний эрчмийг сайжруулах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, олон улсын норм дүрэм, стандартад нийцүүлэн төлөвлөх, иргэдийг ая тухтай саадгүй зорчуулах, хотыг өнгө үзэмжтэй болгох, түгжрэлийг багасгах, хөдөлгөөний нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэхэд гол зорилготой.

2.18.8. Улаанбаатар хотын нийтийн аж ахуйн үйлчилгээг сайжруулах, гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр–2 дугаар үе шат

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	37.1 сая ам.доллар, 21.6 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2017-2023
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	175.1 сая төгрөг

Олон шатлалт санхүүжилтийн хэрэгслийн 2 дугаар үе шатны хүрээнд: (i) хотын хойд хэсэг болох Дамбадаржаа болон Дэнжийн 1000 орчмын гэр хорооллыг дахин төлөвлөж, хотын дэд бүтцийг сайжруулан тэлж, 1 дүгээр үе шатанд хамрагдсан Сэлбэ болон Баянхошуу дэд төвүүдэд нэмэлт хөрөнгө оруулалт хийх; (ii) нийгэм-эдийн засгийн байгууламжийн хүрэлцээг нэмэгдүүлэх; (iii) институцийг бэхжүүлэх болон чадавхыг бий болгох ажлыг үргэлжлүүлэн хийнэ.

2.18.9. Улаанбаатар хотын төлбөрийн чадварт нийцсэн орон сууц ба дахин төлөвлөлтийн төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	80.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2023
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	52.5 сая төгрөг

Төлбөрийн чадварт нийцсэн, байгаль орчинд ээлтэй орон сууцыг барих, гэр хорооллыг дахин төлөвлөх хөтөлбөрийн хүрээнд ногоон байгууламжийг бий болгох, ингэснээр агаар болон хөрсний бохирдлыг бууруулж, гэр хорооллын иргэдийн амьдрах орчныг сайжруулна. Мөн, хувийн хэвшлийн оролцоог дэмжиж, ажлын байр бий болгоно.

2.18.10. Хог хаягдлын менежмент, дахин боловсруулалтын төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Буцалтгүй тусламж
Санхүүжилтийн нийт хэмжээ	3.0 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2018-2021
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	125.1 сая төгрөг

Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийг сайжруулах замаар иргэдийн эрүүл, аюулгүй таатай орчинд амьдрах нөхцөл, боломжийг бүрдүүлж, хөрсний бохирдлыг багасгах зорилготой.

2.18.11. Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто зам барих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	36.3 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	14,065.1 сая төгрөг

Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замын өргөтгөл, шинэчлэл хийх төслийн хүрээнд өмнө 1960-1970 онд баригдсан ашиглалтын хугацаа 50-с дээш жил болсон авто замыг 4 эгнээ болгон өргөтгөж, техник ашиглалтын түвшинг нэмэгдүүлж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг бий болгоход төслийн зорилго оршиж байна.

2.18.12. Туул гол дээгүүр Баянзүрхийн 288 у/м болон Сонсголонгийн 289.4 у/м төмөр бетон гүүрийг шинээр барих төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	БНХАУ-ын Засгийн газар – Эксим банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	21.5 сая ам.доллар
Төсөл хэрэгжих хугацаа	2016-2019
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	5,295.7 сая төгрөг

Төслийн хүрээнд Улаанбаатар хотод шинээр баригдаж буй замын зорчих хэсэгтэй нийцүүлэн замын хөдөлгөөний шинэ урсгалыг бий болгох, дэд бүтцийг байгуулах зорилгоор гүүр барихад оршино.

Туул гол дээр шинээр барих Баянзүрхийн 288 у/м гүүрний бүтээн байгуулалтын хүрээнд Гачууртын уулзвараас Налайх, Чойрын уулзвар хүртэлх авто замын урсгал бүрийг 2 эгнээ болгон өргөтгөж, техник ашиглалтын төвшнийг нэмэгдүүлж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, Гачууртын уулзвараас Баянзүрхийн товчоо хүртэлх замд нэг урсгалын 3км авто замыг шинээр төлөвлөх юм. Мөн Туул гол дээр шинээр барих Сонсголонгийн 289.4 у/м гүүрний бүтээн байгуулалтын хүрээнд тус гүүртэй холбогдож буй авто замын гүүрний зорчих хэсгийг авто замын зорчих хэсэгтэй уялдуулж өргөтгөж, шинэчлэхээр ажил хийгдэж байна.

2.19. ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

2.18.1. Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төсөл

Санхүүжүүлэгч байгууллага, орон	Азийн хөгжлийн банк
Санхүүжилтийн хэлбэр	Хөнгөлөлттэй зээл
Санхүүжилтийн нийт хэмжээ	9.4 сая ам.доллар, 6.2 сая зээлжих тусгай эрх
Төсөл хэрэгжих хугацаа	2015-2020
2018 оны төсөвт тусгах гадаад санхүүжилт	4,200.0 сая төгрөг

Дархан хотын бохир усны менежмент сайжирч, бохир ус цэвэрлэх төв байгууламж (ТЦБ), ариутгах татуурга болон насосны станцын үйл ажиллагааны төвшинг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Мөн төслөөр Дарханы ус сувгийн байгууллагын удирдлагын чадавхыг бэхжүүлэх, сургалтын болон бодлогын хэлэлцүүлгээр дамжуулан дэмжлэг үзүүлнэ.